

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ЖАРГАЛАНТ СУМЫН 16 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН 2020 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/ 134/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Ховд хот

2021 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh
@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545 Цахим хаяг:
Tsetsegsuren.A@audit.gov.mn

Гэрэл Хөхийн тэнцвэр аудит ХХК

Аудитор: Д.Хишгээ

Утас: 99964238 Цахим хаяг: Hishgee.Da@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

АОУС Аудитын Олон Улсын Стандарт

СТА Санхүүгийн тайлангийн аудит

БСУГ Боловсрол соёл урлагийн газар

СТА Санхүүгийн тайлангийн аудит

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	Error! Bookmark not defined.
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	8
3. Аудитын тайлан	8
3.1. Ерөнхий зүйл	8
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	8
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	9
3.4. Материаллаг байдал	9
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	9
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	11
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.9. Аудитын илрүүлэлт.....	13
Залруулсан алдаа	13
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	13
Аудитын зөвлөмж	13
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	13
4. Менежментийн захидал	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	14

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ. ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цэцэрлэгийн баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ЖАРГАЛАНТ СУМЫН 16 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Д.БОЛОРМАА ТАНАА

2021.02.18 № 465
тантай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Жаргалант сумын 16 дугаар цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жаргалант сумын 16 дугаар цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, сургуулийн өмнөх боловсрол хэрэгжилт зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

021020438

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	16 108 732.0	32 687 872.0
33	АВЛАГА	10.0	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	10.0	-
35	БАРАА МАТЕРИАЛ	16 108 722.0	32 687 872.0
351	Түүхий эд материал	-	591 300.0
35130	Эм боох материал	-	591 300.0
354	Хангамжийн материал	16 108 722.0	32 096 572.0
35410	Бичиг хэргийн материал	190 000.0	530 000.0
35460	Хүнсний материал	844 297.0	631 847.0
35470	Бусад хангамжийн материал	15 074 425.0	30 934 725.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2 153 616 776.0	2 105 467 535.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2 153 616 776.0	2 105 467 535.3
392	Биет хөрөнгө	2 153 121 776.0	2 105 096 285.3
39201	Барилга, байгууламж, орон сууц	1 651 569 857.0	1 651 569 857.0
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(27 526 164.2)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	14 969 080.0	18 314 680.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	(3 103 561.2)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33 152 696.0	41 452 696.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	-	(3 685 405.1)
39214	Бусад үндсэн хөрөнгө	453 430 143.0	453 430 143.0
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(25 355 960.2)
393	Биет бус хөрөнгө	495 000.0	371 250.0
39301	Програм хангамж	495 000.0	495 000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(123 750.0)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2 169 725 508.0	2 138 155 407.3
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2 169 725 508.0	2 138 155 407.3
51	Засгийн газрын хувь оролцоо	2 169 725 508.0	2 138 155 407.3
512	Хуримтлагдсан үр дүн	2 169 725 508.0	2 138 155 407.3
51210	Өмнөх үеийн үр дүн	2 169 725 508.0	2 169 725 508.0
51220	Тайлант үеийн үр дүн	-	(31 570 100.7)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2 169 725 508.0	2 138 155 407.3

2.2 АУДИТ ХИЙСЭН ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2 214 088 916.0	531 427 820.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2 150 732 116.0	-
120	Нийтлэг татварын бус орлого	13 050 000.0	-
120009	Бусад орлого	13 050 000.0	-
122	Тусламжийн орлого	2 137 682 116.0	-
122001	Хандив тусламж /дотоод/	2 137 682 116.0	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	63 356 800.0	531 427 820.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	63 356 800.0	445 679 700.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	53 535 600.0	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	445 679 700.0
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	9 821 200.0	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	84 595 800.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	84 595 800.0
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	1 152 320.0
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	1 152 320.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	44 363 408.0	582 329 920.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	44 363 408.0	582 329 920.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	44 363 408.0	561 713 930.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	27 908 638.0	350 697 756.0
210101	Үндсэн цалин	22 192 707.0	260 987 713.0
210102	Нэмэгдэл	3 460 715.0	49 361 821.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	10 660 000.0

210104	Урамшуулал	2 255 216.0	29 688 222.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		
		3 487 867.0	44 356 687.4
210201	Тэтгэврийн даатгал	2 372 234.2	30 267 138.2
210202	Тэтгэмжийн даатгал	279 086.4	3 523 778.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	223 269.1	2 819 023.0
210204	Ажилгүйдлийн даатгал	55 104.5	699 189.8
210205	Эрүүл мэндийн даатгал	558 172.8	7 047 557.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		
		9 805 200.0	76 135 366.0
210301	Гэрэл, цахилгаан	914 134.0	2 625 748.0
210302	Түлш, халаалт	7 909 427.0	64 030 941.0
210303	Цэвэр, бохир ус	981 639.0	9 478 677.0
2104	Хангамж, бараа материалын зардал		
		806 500.0	3 554 200.0
210401	Бичиг хэрэг	395 500.0	830 200.0
210402	Тээвэр, шатахуун	386 000.0	2 170 400.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	25 000.0	150 000.0
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	403 600.0
2105	Нормативт зардал		
		2 355 203.0	26 233 080.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	2 913 500.0
210502	Хоол, хүнс	1 791 703.0	22 865 580.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	563 500.0	454 000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		
		-	150 000.0
210604	Урсгал засвар	-	150 000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		
		-	576 000.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	576 000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		
		-	60 010 840.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	216 000.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	59 794 840.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		
		-	20 615 990.7
2132	Бусад урсгал шилжүүлэг		
		-	1 152 320.0
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	1 152 320.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		
		-	19 463 670.7
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	19 463 670.7
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2 169 725 508.0	(50 902 100.7)

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	63 356 800.0	531 427 820.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	63 356 800.0	531 427 820.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	63 356 800.0	445 679 700.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	53 535 600.0	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	445 679 700.0
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	9 821 200.0	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		84 595 800.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	84 595 800.0
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		1 152 320.0
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	1 152 320.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	63 356 800.0	531 427 820.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	63 356 800.0	531 427 820.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	63 356 800.0	510 811 829.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	27 907 328.0	351 138 833.4
210101	Үндсэн цалин	22 191 397.0	218 821 575.6
210102	Нэмэгдэл	3 460 715.0	100 850 606.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	3 171 600.0
210104	Урамшуулал	2 255 216.0	28 295 051.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3 489 187.0	43 915 600.0
210201	Тэтгэврийн даатгал	2 372 651.0	29 524 645.0
210202	Тэтгэмжийн даатгал	279 159.0	3 513 200.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	223 347.0	2 810 600.0
210204	Ажилгүйдлийн даатгал	55 812.0	702 700.0
210205	Эрүүл мэндийн даатгал	558 218.0	7 364 455.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9 805 200.0	81 220 366.0
210301	Гэрэл, цахилгаан	914 134.0	2 625 748.0
210302	Түлш, халаалт	7 909 427.0	69 115 941.0
210303	Цэвэр, бохир ус	981 639.0	9 478 677.0
2104	Хангамж, бараа материалын зардал	17 999 185.0	4 511 200.0

210401	Бичиг хэрэг	112 100.0	95 800.0
210402	Тээвэр, шатахуун	386 000.0	2 170 400.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	25 000.0	143 600.0
210404	Ном, хэвлэл	190 000.0	44 300.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17 286 085.0	2 057 100.0
2105	Нормативт зардал	3 192 500.0	27 595 530.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	3 902 800.0
210502	Хоол, хүнс	2 636 000.0	22 653 130.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	556 500.0	1 039 600.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	150 000.0
210604	Урсгал засвар	-	150 000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	591 600.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	15 600.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	576 000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	963 400.0	1 688 700.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	963 400.0	1 688 700.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	20 615 990.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	1 152 320.0
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	1 152 320.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	19 463 670.7
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	19 463 670.7
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C07	Тайлант үеийн үр дүн	2 169 725 508.00	2 169 725 508.00
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2 169 725 508.00	2 169 725 508.00
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2 169 725 508.00	2 169 725 508.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2 169 725 508.00	2 169 725 508.00
D08	Тайлант үеийн үр дүн	(31 570 100.68)	(31 570 100.68)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2 138 155 407.32	2 138 155 407.32

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	530259500.0	510811829.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	530259500.0	510811829.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	530259500.0	510811829.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	351324700.0	351138833.4
210101	Үндсэн цалин	233836400.0	218821575.6
210102	Нэмэгдэл	88105800.0	100850606.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3171600.0	3171600.0
210104	Урамшуулал	26210900.0	28295051.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47428900.0	43915600.0
210201	Тэтгэврийн даатгал	33375900.0	29524645.0
210202	Тэтгэмжийн даатгал	3513200.0	3513200.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2810600.0	2810600.0
210204	Ажилгүйдлийн даатгал	702700.0	702700.0
210205	Эрүүл мэндийн даатгал	7026500.0	7364455.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	84445800.0	81220366.0
210301	Гэрэл, цахилгаан	3200000.0	2625748.0
210302	Түлш, халаалт	71975000.0	69115941.0
210303	Цэвэр, бохир ус	9270800.0	9478677.0
2104	Хангамж, бараа материалын зардал	4511900.0	4511200.0
210401	Бичиг хэрэг	95800.0	95800.0
210402	Тээвэр, шатахуун	2171100.0	2170400.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	143600.0	143600.0
210404	Ном, хэвлэл	44300.0	44300.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2057100.0	2057100.0
2105	Нормативт зардал	40072400.0	27595530.0

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3902800.0	3902800.0
210502	Хоол, хүнс	35130000.0	22653130.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1039600.0	1039600.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	150000.0	150000.0
210604	Урсгал засвар	150000.0	150000.0
2107	Томилолт, зочны зардал	45500.0	0.0
210702	Дотоод албан томилолт	45500.0	0.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	559600.0	591600.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	127600.0	15600.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432000.0	576000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1720700.0	1688700.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1720700.0	1688700.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	530259500.0	510811829.4
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	530259500.0	510811829.4
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	445663700.0	429441463.4
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	84595800.0	81370366.0

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Тайлант онд нэмэлт дансаар орлого зардлын гүйлгээ хийгдээгүй болно.

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Жаргалант сумын 16 дугаар цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг шууд захирагч, цэцэрлэгийн эрхлэгч Д.Болормаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд нормативд зардал/хоол/ унаа, е баримтын бүрдүүлэлт, батлагдсан цалингийн зардлыг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25 -наас 2021 оны 02 дугаар сарын 18-ны хооронд Гэрэлт Хөхийн тэнцвэр аудит ХХК-ны Ховд аймаг дахь салбарын захирал аудитор Д.Хишгээ хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй:

Тус цэцэрлэг нь 2020 онд Баг хамт олноо чадавхжуулж, багш ажилчид, хүүхэд, эцэг эх олон нийтийн оролцоотой иргэд нийтэд нээлттэй, хүүхдэд ээлтэй, үйлчилгээгээр тэргүүлсэн ясли цэцэрлэгийн цогцолбор болох эрхэм зорилтын хүрээнд “Хүүхэд бүрд баяр хөөр эцэг эхэд итгэл найдвар бие биедээ урам зориг бэлэглэсэн –Эрүүл чийрэг, бүтээлч хүүхдийг хөгжүүлж, төлөвшүүлэх анхдагч орчин байна” гэсэн уриалга дэвшүүлэн үйл ажиллагаагаа төлөвлөн ажиллажээ. .

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”

- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай
- Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 450 тоот “Хоолны зардлын норматив тогтоох тухай”

3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Тус байгууллага санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй бөгөөд байгууллагын дотоод хяналт нь 3 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж улирал бүр хяналт тавин ажилладаг байна.

Тухайн оны шилэн дансны мэдээллээ хугацаандаа оруулж улирал тутам тайлангаа илгээсэн тул зөрчил илрээгүй байна.

Сар бүр Жаргалант сумын төрийн сангийн мэргэжилтэн хяналт тавьж, гүйцэтгэлийг үнэлэхэд 99-100%аар дүгнэгдсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд БАГА гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлого сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 314737.0 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 3560.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

Гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт/550759.8/ орлогын 2 хувиар 11015.2 мянган төгрөгөөр тооцлоо.

Алдааны дүн материаллаг бус /эрсдэл бага / үр нөлөөгүй цар тахалын үед ажилчидадаа олгосон унаа, хоол, түлшний урамшуулал нь олон хүнийг хамруулсан учраас дүн өндөр гарч буй учраас аудитын төлөвлөлтийн үед сонгосон МБ-түвшинг өөрчлөн 2 хувь болгов.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 31570.1 мянган төгрөгөөр буюу 1.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	
			Дүн	Хувь
Б	1	2	3=2-1	
Авлага	10.0		10.0	100.0%
Бараа материал	16 108.7	32 687.9	- 16 579.2	-102.9%

Үндсэн хөрөнгө	2 153 616.8	2 105 467.5	48 149.3	2.2%
Нийт хөрөнгө	2 169 735.5	2 138 155.4	31 580.1	1.1%
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2 169 735.5	2 138 155.4	31 580.1	1.1%
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2 169 735.5	2 138 155.4	31 580.1	1.1%

Бараа материалын дансны үлдэгдэл 32687.9 мянган төгрөг болж өмнөх оноос 16579.2 мянган төгрөгөөр өссөн нь 2020 онд нийт 43023.5 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж, 26444.4 мянган төгрөгийн бараа материал зарлагджээ.

Бараа материалын тайланд нийт 9533,1 мянган төгрөг хандиваар нэмэгдсэн нь Тайваны гэр бүлийг дэмжих сангаас 5090.5 мянган төгрөгийн хөнжил гудас, углаа дэвсээ, тоглоом, ДЗОУБ 3262.6 мянган төгрөгийн тоглоом хүлээн авч данс бүртгэлд бүрэн тусгасан байна.

Эм боох материалын үлдэгдэл 591.3 мянган төгрөгийн үлдэгдэл нь Жаргалант сумын Засаг даргын 2020-03-20-ны № 1/288 тоот албан бичиг/Жаргалант сумын ЕБС, СӨБ-ыг гамшгаас хамгаалах аюулгүй байдлын нөөцийн жишиг жагсаалт/, 2020-03-13-ны өдрийн Жаргалант сумын онцгой комиссын хурлын шийдвэр № 05 шийдвэрээр эм боох материалын зардал дээр нөөц бэлтгэсэнтэй холбоотой байна.

Хүнсний материалын үлдэгдэл 631.8 мянган төгрөг байгаа нь МУ-ын боловсрол шинжлэх ухааны сайдын 2020-11-27-ны А/162 тоот тушаалаар тус цэцэрлэг хоол хүнс тэжээлийн дутагдалд өртөх эрсдэл бүхий өөрийн цэцэрлэгт хамрагддаг 18 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн орсон 56423 төгрөгийн нэг бүрийн үнэтэй 959.2 мянган төгрөгийн үнэ бүхий хоол хүнсийг 17 хүүхдэд олгосон байна.

Бичиг хэрэг 530.0, бусад хангамжийн материал БҮТЭЗ 30934.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2165262.4 мянган төгрөг болж 11645.6 мянган төгрөгөөр өссөн төсвийн хөрөнгөөр 1846.7, хандиваар 9798.9 мянган төгрөгөөр тус тус өссөн байна. Багш ажилчид, эцэг эхчүүдийн хандиваар 1498.9 мянган төгрөгөөр 2 ш зурагт, Жаргалант сумын ОНХСангийн 8300.0 мянган төгрөгийн хөрөнгөөр анги бүрд хивс авсныг орлого авч данс бүртгэлд тусгасан байна.

2019 онд байгуулагдсан цэцэрлэг учраас үндсэн хөрөнгө дансны хуримтлагдсан элэгдэл байхгүй тайлант онд 59794.9 мянган төгрөгийн элэгдлийн зардлаар үндсэн хөрөнгө хасагдсан байна.

Биет бус хөрөнгийн дансанд ямар нэгэн өөрчлөлт гараагүй байна.

Тус байгууллага өр төлбөр дансны үлдэгдэлгүй .

Засгийн газрын оролцоо дансанд өөрчлөлт ороогүй байна.

2020-оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1663329.1 мянган төгрөгөөр буурсан нь өмнө онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барилга байгууламж ашиглалтад орсонтой холбоотой байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 468071.12 мянган төгрөгийн орлого нь өмнөх оноос тусгай зориулалтын болон орон нутгийн санхүүгийн дэмжлэг нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	зөрүү
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2 214 088.9	550 759.8	1 663 329.10
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2 150 732.1	-	2 150 732.12
Нийтлэг татварын бус орлого	13 050.0	-	13 050.00
Хандив тусламж /дотоод/	2 137 682.1	19 332.0	2 118 350.12

ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	63 356.8	531 427.8	-	468 071.02
Улсын төвлөрсөн төсвөөс	63 356.8	445 679.7	-	382 322.90
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	84 595.8	-	84 595.80
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	1 152.3	-	1 152.32

Нийт зардал өмнөх оноос 537966.5 мянган төгрөгөөр өссөн нь 2019 онд шинээр байгуулагдаад 1-2 сар л үйл ажиллагаа явуулсантай холбоотой.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 322789.1, нийгмийн даатгалын шимтгэл 40868.8, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлууд 66330.2, хангамжийн бараа материалын зардал 2747.7, нормативт зардал 23877.9, бараа үйлчилгээний бусад зардал 60010.8, буцаан төвлөрүүлсэн 19463.7 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	44 363.4	582 329.9	-	537 966.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	27 908.6	350 697.8	-	322 789.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3 487.9	44 356.7	-	40 868.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9 805.2	76 135.4	-	66 330.2
2104	Хангамж, бараа материалын зардал	806.5	3 554.2	-	2 747.7
2105	Нормативт зардал	2 355.2	26 233.1	-	23 877.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	150.0	-	150.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	576.0	-	576.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	60 010.8	-	60 010.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	20 616.0	-	20 616.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	1 152.3	-	1 152.3
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	19 463.7	-	19 463.7
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>2 169 725.5</u>	<u>(31 570.1)</u>		<u>2 201 295.6</u>

Энэ нь өмнөх оноос цалин хөлсний зардалд төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл шинээр тооцогдон олгогдсон, төсвийн хэмнэлтээс буцаан төвлөрүүлсэн зэргээс хамаарчээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан ямар нэгэн өөрчлөлт байхгүй.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 575847.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 575847.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төсөлд 2020 онд хасах тодотгол хийж 45571.6 мянган төгрөгөөр бууруулж 530259.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасан Коронавируст халдвар/ковид-19/ цар тахалтай холбоотой анх батлагдсан төсвөөс хасаж тодотгол хийсэн 45571.6, оны сүүлчээр зарцуулаагүй үлдэгдэл санхүүгийн дэмжлэгээ буцаан төвлөрүүлсэн 19463.7 бүгд 65035.3 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг зарцуулаагүй байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 530275.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 445679.7 мянган төгрөгийг

тусгай зориулалтын санхүүгийн дэмжлэгээр, 84595.8 мянган төгрөгийг орон нутгийн санхүүгийн дэмжлэгээр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 530275.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 510811.8 мянган төгрөгийг зарцуулж 19463.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 510811.8 мянган төгрөг буюу 96 хувьтай буюу 19463.7 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

Үзүүлэлт	Тайлант оны		
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	530275.5	510811.8	19463.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	351324.7	351138.8	185.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47428.9	43915.6	3513.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	84445.8	81220.4	3225.4
Хангамж, бараа материалын зардал	4511.9	4511.2	0.7
Нормативт зардал	40072.4	27595.5	12476.9
Эд хогшил, урсгал засварын зардал	150.0	150.0	0.0
Томилолт, зочны зардал	45.5	0.0	45.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	575.6	591.6	16.0
Бараа үйлчилгээний бусад зардал	1720.7	1688.7	32.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	530275.5	510811.8	19463.7
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	445679.7	429441.5	16238.2
орон нутгийн санхүүгийн дэмжлэг	84595.8	81370.4	3225.4

- ✚ Энэ нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 185.9 мянган төгрөгөөр хэмнэсэн нь тухайн онд ковид-19 буюу цар тахалтай холбоотой цэцэрлэгийн үйл ажиллагаа хэдэн сараар хүүхэд авахгүй хойшилсон, энэ үед багш, туслах багш нарын илүү цагийн хөлс олгоогүй, жирэмсэн болон хүүхдээ асарч байгаа багшийн оронд түр ажиллаж байсан багшийг амрааж цалинг хэмнэсэн зэргээс шалтгаалжээ.
- ✚ Оны эцэст Коронавируст халдвар ковид-19 цар тахалтай холбоотой үйл ажиллагаа тасалдсанаас батлагдсан төсөвт зардал хэмнэсэнтэй холбоотой өмнөх оноос өссөн цалингийн өсөлтийн 28.3 хувь буюу 7488.4 мянган төгрөгийг унаа, хоол, түлшний хөнгөлөлтөд олгосон байна.
- ✚ Нийгмийн даатгалын шимтгэл: 3513.3 мянган төгрөгөөр хэмнэсэн нь анх төсөв төлөвлөхдөө нэг хувийн илүү тооцоололт хийгдсэн тул тухайн санд үлдээн буцаан төвлөрүүлсэн байна.
- ✚ Хоол хүнс 12476.9, урсгал засвар 155.7, дотоод томилолт 45.5, бараа үйлчилгээний бусад зардал 32.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь Ковид-19 буюу цар тахалтай холбоотойгоор цэцэрлэгийн үйл ажиллагаа зарим сард ажиллаагүй, зарим сард хагас ажилласан, тайлант онд томилолтоор багш ажилтан яваагүй, зуны улиралд ээлжийн бүлэг ажиллаагүй зэрэгтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд тус байгууллагын нэмэлт дансаар орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан. 151 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус цэцэрлэг нь 2019 оны 11-р сард байгуулагдсан түүвэрт хамрагдан тайланг нэгтгүүлж, аудит хийгдээгүй тул аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 7602.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 7602.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулга хийгдээгүй болно.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар залруулагдаагүй алдаа, зөрчил байхгүй.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 7602.1 мянган төгрөгийн алдаа, зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараах 2 асуудлыг аймгийн ТЕЗ-ын нэгтгэсэн тайлангийн үеэр анхаарал хандуулж дахин хянаж хэрэгжилтийг нэгтгэн хянах шаардлагатай байна. Үүнд:

- 2020-09-03-ны өдрийн А/483 тоот Ховд аймгийн Засаг даргын захирамжаар Жаргалант сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүүхдийн анги танхим байрны дотоод орчны агаарын чанарыг сайжруулан дэвшилтэт технологи болох “Окфил” агаар шүүгчийг суулгах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсэн байна. Тус цэцэрлэгт 45 ширхгийг 9 ангид 5085.0 мянган төгрөгөөр нийлүүлсэн,
- 2020 оны 02 сарын 18-ны Ховд аймгийн Засаг даргын А/107 тоот захирамжаар “Урьдчилан сэргийлэх арга хэмжээний хөрөнгө гаргах тухай захирамжаар Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмнэлтээс 380.0 мянган төгрөгийн маск нийлүүлэх гэрээ хийж Буянт үйлийн шим ХХК-д шилжүүлсэн
- БСУГ-аас хөрөнгө оруулалтаар Dell latitude 3400 CTO Business model 2 ширхэг нөтөбүүкийг нэг бүрийг 1749500 төгрөгөөр 3499.0 төгрөгөөр бэлтгэсэн зэрэг асуудлуудыг аймгийн ТЕЗ-ын нэгтгэсэн тайлангаар авч үзэх шаардлагатай байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Норматив зардал /Хоол/

- 1.1. *Илрүүлэлт: Тайлант онд* нийт 8897 хүүхэд өдөрт 21906.4 мянган төгрөг хоолонд зарцуулж нэг хүүхдэд 2462.0 төгрөг ноогдож, норматив /2475/ зардлаас 13.0 төгрөгөөр дутуу зарцуулж нийт 113.7 мянган төгрөгийн хоол дутуу олгосон байна Үнэлгээ, Хэмжилт, Үнэн зөв байдал зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна МУЗГ-ын тогтоол зөрчсөн байна.
- 1.2. *Эрсдэл: хууль, дүрэм, журам зөрчигдөх*
Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 450 тоот “Хоолны зардлын норматив тогтоох тухай” тогтоолыг мөрдөх
- 1.3. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: *Зөвшөөрч байна.*

И-баримтын бүрдүүлэлт

2.1. *Илрүүлэлт:* Татварын нэгдсэн системд холбогдсон бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжээс хэвлэсэн төлбөрийн баримт дутуу байна.

2.2. *Эрсдэл:* тайлан буруу илэрхийлэгдэх, хуурамч зарлага гаргах

2.3. *Өгсөн зөвлөмж:* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх зарчмыг баримтлан ажиллах

2.4. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* *Зөвшөөрсөн*

Цалингийн зардал /хоол, унаа, түлшний хөнгөлөлт/

3.1. *Илрүүлэлт:* Оны эцэст Коронавируст халдвар ковид-19-ын цар тахалтай холбоотой үйл ажиллагаа тасалдсанаас батлагдсан төсөвт зардал хэмнэсэнтэй холбоотой 7488.4 мянган төгрөгийн унаа хоолны хөнгөлөлтийг нэр бүхий 38 албан хаагчдад олгосон байна.

3.2. *Эрсдэл:* төсвийн хөрөнгийг буруу зарцуулах, эдийн засгийн ангилал зөрчих, төсвийн төлөвлөлт буруу төлөвлөх

3.3. *Өгсөн зөвлөмж:* Төсвийн тухай хуулийн 4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах зарчмыг баримтлан ажиллах

3.4. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* *Хүлээн зөвшөөрсөн*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Жаргалант сумын 16 дугаар цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			ХОА-2021/134/СТА-

Шалгагдсан
байгууллагын нэр:

Жаргалант сумын 16 дугаар цэцэрлэг

Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Хоолны зардлын нормативыг дутуу олгосон.	113.7	Зөвлөмж	Захирал	Д.Болормаа
2	Татварын нэгдсэн системд холбогдсон бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжээс хэвлэсэн төлбөрийн баримт дутуу		Зөвлөмж	Захирал	Д.Болормаа
3	Батлагдсан төсөвт зардал хэмнэсэнтэй холбоотой 7488.4 мянган төгрөгийг унаа хоолны хөнгөлөлтийг нэр бүхий 38 албан хаагчдад олгосон байна.	7488.4	Зөвлөмж	Захирал	Д.Болормаа
ДҮН		7602.1			

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР

Огноо:2021. 02.18

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЦЭГСҮРЭН

Огноо:2021.02.18

БЭЛТГЭСЭН:

ГЭРЭЛТ ХӨХИЙН ТЭНЦВЭР АУДИТ ХХК-НЫ ХОВД АЙМАГ ДАХЬ
САЛБАРЫН ЗАХИРАЛ, АУДИТОР

Д.ХИШГЭЭ

Огноо:2021. 02.18

